

“ОЛНЫ СЭТГЭЛ ХӨДӨЛГӨСӨН ЭЛДЭВ ЗҮЙЛИЙН БОДЛОГОТ
БИЧИГ” ГЭЖ ЮУГ ХЭЛЖ БАЙНА ВЭ?

Т.Баасансүрэн*

*УБЭИС-ийн Сэтгүүл зүй, олон улс судлалын тэнхимийн эрхлэгч, доктор (Ph,D), профессор

Түлхүүр үгс: Нийслэл Хүрээ, хувьсгалт нууц бүлгэмүүд, Монгол Ардын Нам, хувьсгалын нууц ухуулах хуудсууд, “Монголын үнэн” сонин, Монгол-Түвдийн хэлтэс

Нийслэл Хүрээнд үйл ажиллагаагаа нууцаар явуулж байсан хувьсгалт хоёр бүлгэм 1920 оны 6 дугаар сарын 25-нд нэгдэж Ардын нам хэмээх улс төрийн нууц байгууллагыг үүсгэж, намын нөхдийн дагаж мөрдөх “Тангаргын бичиг”-ийг /гэрээг/ байгуулжээ. Өмнө нь хувьсгалт нууц бүлгэмүүд тус тусдаа ажиллаж байв. 1919 оны намраас Хүрээний ил задгай гудамж талбайд нууц ухуулах хуудас наалдуулж хувьсгалт тэмцлийн замдаа шуудран орсон байдаг. Тэдний үндсэн гол зорилго бол Хятадын эзлэн түрэмгийлэгчдийг эх нутгаасаа хөөн зайлуулж, хүчээр устгуулсан Монгол Улсын тусгаар тогтнолоо сэргээн мандуулах явдал байв.

Гэмингийн харгислал түрэмгийллийг эсэргүүцэн тэмцэж илчлэн хүн ардын сэтгэлийг татах, өөрсдийн тэмцлийн утга учрыг олон түмэнд

ойлгуулж таниулахад тухайн цаг үед хамгийн тохиромжтой, хурц дайчин хэлбэр нь ухуулах хуудас мөнийг ухаарч ойлгосон Д.Сүхбаатар хувьсгалт бүлгэмийн нэгэн цуглаан дээр “Одоо бид энэхүү харгис хорт гэмингийн байдлыг үзэж, нэг ч өдөр зүгээр суухад хорсол заналтай тул хятад гэминг харааж дайрах ба мөн Монголын эрхийг барьж байсан лам ноёд, харгис Сүй Шу-женийг хооронд нь эвдрүүлж хутгаж, мөн Монголын ард түмэнд эл явдлыг нэвтрүүлэн мэдэгдэж, эсэргүүцэн хөдөлгөхөд гүнээ уялдуулан уриалсан утгатай нууц бичгийг энд тэнд наалдуулбал ямар” (Сүхбаатар., 1959) гэж санал гаргасныг журмын нөхөд нь нэгэн дуугаар дэмжин зөвшөөрч, удалгүй Хүрээний хүмүүсийн олноор цуглардаг газруудын хашаа байшингийн хананд хувьсгалчдын ухуулах хуудас үзэгдэж эхэлжээ.

Ийм ухуулах хуудсууд 1919 оны намраас 1921 оны 7 дугаар сарын хооронд тарж, нилээдийг нь сүүлд хилийн чанад Эрхүү хотноо хэвлэж байсныг, энэ нь манайд хувьсгалт хэвлэл үүсэн буй болох үндэс нөхцлийг бүрдүүлэхэд түлхэц үзүүлс-

нийг доктор Г.Дэлэг, Л.Норовсүрэн, Л.Түдэв нарын судлаачид тэмдэглэсэн байдаг билээ. Тухайлбал доктор Л.Норовсүрэн “Цаг үеэ шуурхай тусгадаг утга зохиолын дайчин хэлбэрийг бичгээр түгээх явцад тохиолдсон сонирхолтой үзэгдлийн нэг нь ухуулах хуудас юм” (Л.Норовсүрэн, 2019) гэжээ.

Ингэж шийдвэртэй тэмцлийн замд шуудран орсон Монголын хувьсгалчид үйл ажиллагаагаа улам идэвхжүүлж, улмаар ялалтад хүрэхийн тулд хөрш зэргэлдээх Орос улсаас тусламж гуйхаар өөрсдийн төлөөлөгчдийг илгээхээр тогтсон байна. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Д.Бодоо, С.Данзан, Д.Догсом, Д.Лосол, Д.Чагдаржав нар орсон бөгөөд тэдэнд Богд хааны дагалдах хүсэлт бичиг ч байв.

1920 оны 8 дугаар сарын 16-нд Эрхүү хотноо хүрэлцэн очсон тэднийг маргааш нь Сибирь, Алс дорнодын гадаад хэргийн бүрэн эрхэт төлөөлөгчийн орлогч Ф.Гапон хүлээн авч уулзжээ. Энэ цаг үед Эрхүү хотноо Коминтерний алс дорнодын салбар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байв.

Хүрээн дэх хувьсгалт тэмцлийн нууц бүлгэмүүдийг нэгтгэж Монгол Ардын Намыг үүсгэн “Тангаргын бичиг”-ээ баталж, хувьсгалт тэмцлийн зам, зорилгоо нэгэнт тодорхойлчихоод байсан Монголын хувьсгалчид цэрэг зэвсэг, санхүү эдийн засаг, дипломатын чиглэлээр Оросын талаас авах тусламжийн агуулгаа анхны уулзалт дээр илэрхийлэхэд нь айлын тал эдгээр санал хүсэлтээ албан ёсны бичгээр гаргаж өгөхийг шаардсан байна.

Монголын төлөөлөгчдийг Оросын тал ийнхүү нааштайгаар хүлээн авч санал хүсэлтээ бичгээр гаргаж өгөхийг зөвлөсний дагуу Х.Чойбалсан нар “Хүрээний газар ардын намын гол хороог байгуулж хэргийг хөтлөх хүмүүсийг сонгоод, **нэгд**, олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана” хэмээн “Намын ойрын зорилтын талаарх санал”-даа бичиж өгчээ. /Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүхийн 5 дугаар зүйл, Х.Чойбалсаныг дангаар бичсэн “Монголын хувьсгалын түүх” номын 4 дүгээр зүйлийг харна уу/.

Айлын талд Ардын Намын төлөөлөгчдийн тавьсан хүсэлт дотор “Хэмжээ багатай ухуулах хуудас, уриалга зэргийг хэвлэж болох жижигхэн чулуун барын хэвлэх үйлдвэр зайлшгүй хэрэгтэй байна. Дараа нь мөн эндээ, Эрхүүд монгол хэл дээр зохиол хэвлэх ажлыг зохион байгуулах зайлшгүй хэрэгтэй” (Б.Галаарид, 2021) хэмээн Протокол № 2-т тэмдэглэж үлдээснийг судлаач Б.Галаарид өөрийн номондоо ишлэж баримт болгож дурдсан байна.

Эдгээрээс харахад Монголын хувьсгалчид цэрэг зэвсэг, санхүү эдийн засаг, дипломатын чиглэлээр авах тусламж дотроо ухуулга сурталчилгаа, хэвлэл мэдээллийн тусламжийг онцгойлон хүсэж, айлын талд албан ёсоор тавьж байсан нь тод харагдаж байгаа юм. Түүнийг нь орос нөхөд, Коминтерний Алс Дорнодын Хорооныхон ойлгон хүлээн авч ОК/б/Н-ын Сибирийн товчооны Монгол-Түвдийн хэлтсийг зохион байгуулах ажлыг

яаравчлан хэрэгжүүлж, уг зохион байгуулалтын ажилд Монгол Ардын Намын төлөөлөгчдийг татан оролцуулж /Д.Бодоо, Х.Чойбалсан нар/ хамтран шийдвэрлэсэн байна. Эл хурлаас Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарыг Монгол-Түвдийн хэлтсийн ятгалга-ухуулга-хэвлэлийн дэд хэлтэс /агитационно-пропагандистско-издательский подотдел/-ийн ажилд татан оролцуулах /привлечь/, Х.Чойбалсанг болохоор бүр редакцын зөвлөлийн гишүүний эрхтэйгээр оролцуулж байхаар шийдвэрлэжээ.

1 1921 оны ардын хувьсгалын анхдагчид, тухайлбал Х.Чойбалсан, Д.Лосол, Д.Сүхбаатар нар 1920 оны 8 дугаар сард Орос улсаас тусламж хүссэн “Намын ойрын зорилтын талаарх санал”-даа “Тавдугаар зүйл. Хүрээний газар ардын намын гол хороог байгуулж хэргийг хөтлөх хүмүүсийг сонгоод, Нэгд, олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана. Хоёрт, Намыг хамгаалах нууц цэргийн хүн нарыг байгуулан тогтооно. Гуравт, бичиг цэргийн оньсон арга сургах сургуулийн хүн нарыг Эрхүү хотын газар илгээх ба олон газрын Ардын нам лугаа нэвтрэлцэх хэргийг эрхэлнэ” (Чойбалсан.Х, Лосол.Д, Дэмид.Г, 2014) хэмээн айлын талд өөрсдийн үндсэн зорилгыг бичиж тодотгоод өргөн барьсан байна.

Тавдугаар зүйлийн нэгд буюу өөрөөр хэлбэл тэргүүн ээлжинд “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогт бичиг хэвлэн гаргана” гэж онцолжээ. Үүнийг нь судлаач Б.Галаарид орос хэл дээрх эхтэй нь мөн тулган харгалдуулсан байх агаад Монголоос орос руу хөрвүүлэх-

дээ “1. Ухуулга-хэвлэлийн” гэж тодотгожээ.

“Коминтерний баримтуудаас үзвэл 1920 оны наймдугаар сарын 18-20-ны хооронд урьдчилсан тусгай уулзалт дээр хэвлэх үйлдвэр, хэвлэлийн асуудлыг Монголын талаас анх хөндсөн... Монголын талаас Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Д.Лосол нар оролцсон байх магадлалтай нь ЗХУ-ын Сибирь, Алс Дорнодын гадаад хэргийн Ардын Комиссариатын газрын бүрэн эрхэт төлөөлөгчийн орлогч Ф.И.Гапоноос Сибирийн хувьсгалт зөвлөлийн дарга И.Н.Смирновт бичсэн зурвасаас анзаарагдаж байна” (Б.Галаарид, 2021) гэж доктор Б.Галаарид өөрийн судалгааны номондоо дурдсан байна.

Өөрөөр хэлбэл гурван өдөр үргэлжилсэн уг урьдчилсан тусгай уулзалтын явцад хэвлэх үйлдвэр хийгээд хэвлэлийн сурталчилгааны асуудлаарх саналыг Монголын талаас анх хөндөж тавьжээ. Түүнийг нь айлын тал нааштайгаар хүлээн авч дэмжээд “Монголын үнэн” сонин, Ардын хувьсгалчдын ухуулах хуудсуудыг хэвлүүлэхэд өөрсдийн сэтгэл харамгүй туслалцааг үзүүлсэн байдаг билээ.

Дээр дурдсан баримтуудаас харахад хэд хэдэн зүйл тун тодорхой ойлгогдож байгаа юм. Нэгд, 1920 оны 8 дугаар сарын 18-20-нд Эрхүү хотноо болсон хоёр талын уулзалт дээр Монгол Ардын Намын төлөөлөгчид хэвлэх үйлдвэр, хэвлэлийн асуудлыг анх хөндөж тавьжээ. Санал айлын талаас биш, манай талаас гарчээ. Айлын тал тэрхүү саналыг нь нааштайгаар хүлээж авсан байна. Хоёрт, Монгол Ардын Намын

төлөөлөгчдийн эх орондоо ардын хувьсгал хийх, түүний зорилго зорилтыг зэвсэгт тэмцлийн замаар гүйцэтгүүлэх санал, төлөвлөгөөг сайшаасан нь цэрэг, зэвсгийн тусламж үзүүлэх болсноос аяндаа мэдрэгдэнэ. Гуравт, энэхүү хувьсгалт тэмцлийг үзэл суртлын талаар хангах зайлшгүй шаардлагатайд хоёр тал санал нэгдэж Монголын хувьсгалчдын нууц хэвлэл “Монголын үнэн” сониныг, хувьсгалт ухуулах хуудсуудыг Эрхүү хотноо хэвлэхэд тусалжээ. Энэ бол маш том дэмжлэг байв. Дөрөвт, эдгээр ажлыг газар дээр нь удирдан зохион байгуулах, практик ажил хэрэг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй ОК/б/Н-ын Сибирийн товчооны Монгол-Түвдийн хэлтсийг зохион байгуулах хуралд Д.Бодоо, Х.Чойбалсан нар биечлэн оролцжээ. ОК/б/Н-ын Сибирийн товчооны Монгол-Түвдийн хэлтэс /агитационно-пропагандиско-издательский подотдел/-ийн ажилд Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарыг татан оролцуулах /привлечь/, тэгэхдээ Х.Чойбалсанг редакцын зөвлөлийн гишүүний эрхтэйгээр оролцуулахаар уг хурлаас шийдвэрлэсэн байна. Энэ тухайг албан ёсны протоколд тэмдэглэж үлдээжээ (Протокол № 1 организационного заседания коллегии Монголо-Тибетского отдела секции восточных народов Сиббюро РКП /б/ 20 августа 1920 г-Монголия в документах Комминтерна /1919-1934/ в 2 ч3-ч1 /1919-1929/).

Монгол хэл дээрх хэвлэлийн түүхийг анх удаа өргөн цар хүрээнд ул суурьтай, нухацтайгаар авч үзэж судлаад 1965 онд “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” хэмээх

ном туурвисан доктор Г.Дэлэг 1920 оны дээрх үйл явдалд биечилж оролцсон, улмаар 1921 оны ардын хувьсгалыг үүсгэж, шинэ Монгол улсын өмнө тулгарсан зорилтуудыг гардаж хэрэгжүүлсэн Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нарын 1934 онд хамтран бичсэн “Монгол Ардын үндэсний хувьсгал үүсэж байгуулагдсан товч түүх” хэмээх намын түүхэн баримтад үндэслэж айлын талд ардын хувьсгалчдаас хүсэлт болгож тавьсан “Зурагтай ухуулах сэтгүүл” гэдгийг өөрийн номондоо “Монголын үнэн” (Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл, 1965) сониныг хэлж буй гэж тодотгож тайлбарласан байна.

Харин үүнийг нь доктор Б.Галаарид “Зурагтай ухуулах сэтгүүл” гэдгийг Г.Дэлэг “Монголын үнэн” гэж давхар хаалтад тайлбарласан нь буруу ойлголтыг буй болгож хувьсгалт хэвлэлийн цаашдын судалгаанд уг ойлголт лавширч хэвшихэд хүргэсэн хэмээх санааг илэрхийлээд “Монголын үнэн” сонины тухайд доктор Г.Дэлэг анх 1960-аад онд томьёолж, дараа дараагийн судлаачид хүлээн зөвшөөрсөн “Монгол Ардын Намын анхны хэвлэл” гэх дүгнэлтээс татгалзаж, “Монголын үнэн” сонин бол Коминтернээс дорно дахины ард түмнүүдэд пролетарийн интернационализмын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ард түмэн бүрийн хэл дээр сонин хэвлэл бэлтгэн түгээх том төслийн нэгээхэн хэсэг, монголчуудад зориулж монгол хэл бичгээр гаргасан сонин бөгөөд Монголын хувьсгалчид энэ сониныг бэлтгэх, түгээх ажилд оролцож, хамтран ажилласан байна гэдгийг хүлээн

зөвшөөрөх цаг нэгэнт болжээ (Б.Галаарид, 2021) гэж бичсэн байна.

Дээр дурдсан эсрэг тэсрэг хоёр үнэлэлт дүгнэлтээс 1920 оны 11 дүгээр сарын 10-нд анхных нь дугаар хэвлэгдэн гарсан “Монголын үнэн” чинь тэгээд манай сонин уу, хүний сонин уу гэсэн асуулт аяндаа урган гарч байгаа болно. Энэхүү асуултад миний бие “Монголын үнэн” сонин монголчуудын оюун санааны үнэт өв, монгол үндэстний өмч мөн” /Доктор, профессор М.Зулькафилль өмнөх үг бичин редакторлаж, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, МУСГЗ, “Үнэн” сонины ахмад ажилтан Х.Цэвлээгийн тайлбар өгүүллийг дагалдуулсан, УБ.2024/ хэмээх судалгааны бүтээлээрээ өөрийн дэлгэрэнгүй хариултыг өгсөн гэж бодож байна.

1920 онд Монгол Ардын Намыг төлөөлж /Хүрээний нууц бүлгэмүүд нэгдсэний дараахан/ Эрхүү хотноо Орос улсад тусламж гуйж очсон Монголын хувьсгалчид “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг” гэсэн нэр томъёог хэрэглэжээ. Энэ ер нь юу гэсэн үг вэ? 1920 онд Орос улсад тусламж гуйж очсон хувьсгалчид ямар утгаар дээрх нэр томъёог хэрэглэв. Г.Дэлэг доктор үнэн яриад байна уу, Б.Галаарид судлаачийн үндэслэлд өөр шинэ өнцөг байна уу, яагаад МАН-ын анхны хэвлэл биш гэж үзэв хэмээн бодоод холбогдох үүх түүх онгичиж, ном зохиол эргүүлж тойруулж үзэхэд зарим зүйл тодорч эхлэх шиг санагдсан.

“Эрхүүгийн эрх баригчдад илэрхийлэн хэлж тус намын хэрэг ажлыг олон түмэнд зарлах элдэв бичиг зарлал ба мөн харгис гэмин,

зандалчин цагааныг муутган шүүмжилсэн, элэглэн дуурайлгасан зурагтай ухуулах сэтгүүлийг гаргаж олны сэтгэлийг татах, харгис зандалчингаас жигшүүлэн салгаж авах бодлоготой хэвлэлийн ажлыг тэнд гүйцэтгэхээр тогтсон боловч хотод монгол хэл бичиг мэдэх хүнгүй бөгөөд энэхүү намын хэвлэлийн ажилд монгол бичиг сайн мэдэх хүн чухал хэрэглэгдэх тул эндээс явуулан эл ажилд туслалцан гүйцэтгэж байхаар тогтоод та нарын хойноос яаравчлан ирэв”. Энэ бол МАН-ын төлөөлөгчдөөс Эрхүүд 1920 онд түр хугацаагаар үлдсэн С.Данзангийн үг. Доктор Г.Дэлэг “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” /УБ.1965. 226 дахь тал/ номондоо Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нарын “Монгол Ардын үндэсний хувьсгал үүсэж байгуулагдсан товч түүх” номын 1934 оны хэвлэлтийн 281-282 дахь талаас авч ийнхүү эшлэжээ.

1920 онд Оросод тусламж гуйж очсон Монгол Ардын Намын анхдагч долоогийн нэг С.Данзангийн хэлсэн дээрх үгийг ихэд анхааран уншихыг би уншигч танаас болон Монголын сэтгүүл зүйн бусад судлаачдаас хичээнгүйлэн хүсэж байна. “Монголын үнэн” сонинтой холбоотой тодорхой мэдээлэл үүн дотор агуулагдаж байгаа юм. С.Данзан яах гэж Эрхүүгээс яаравчлан ирснээ маш тодорхой, туйлын ойлгомжтойгоор тайлбарласныг Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нар өөрсдийн бичсэн “Монгол Ардын Намын үндэсний хувьсгал үүсэж байгуулагдсан товч түүх” номондоо дээрх байдлаар тэмдэглэж үлдээжээ.

Хэвлэх үйлдвэр, хэвлэлийн сурталчилгааны асуудлыг Монгол Ардын Намын төлөөлөгчид айлын талд анх хөндөж тавьсан, тэдгэрийгээ бичгээр гаргаж өг гэж Коминтернээс шаардсаны дагуу Монголын хувьсгалчдын

бичиж боловсруулж бэлтгээд айлын талд гардуулсан “Гадаад Монголын Ардын Хувьсгалт Намын ойрын зорилтын санал”-ын 5 дугаар зүйлийн нэгд, “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана” гэсэн томьёоллын утга агуулга нь С.Данзангийн дээрх яриа, түүнийг Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нар “Монгол Ардын Намын үндэсний хувьсгал үүсэж байгуулагдсан товч түүх” номонд тэмдэглэж үлдээсэн тэмдэглэлээс яг үндсэн өнгө төрхөөрөө тодрон дурайж харагдана. Үүнд:

–“Намын хэрэг ажлыг олон түмэнд зарлах элдэв бичиг зарлал” гэжээ.

–Энэ нь “харгис гэмн, зандалчин цагааныг муушаан шүүмжилсэн, элэглэн дуурайлгасан зурагтай ухуулах сэтгүүл” байна гэсэн байна. Ухуулах хуудас, уриа лоозон гэсэн-

гүй, зурагтай ухуулах сэтгүүл байна гэж ямар ч хоёрдмол утгагүйгээр тодорхойлжээ.

–Түүнийг буюу “сэтгүүл гаргаж олны сэтгэлийг татах” гэж онцолжээ.

–“Харгис зандалчингаас жигшүүлэн салгаж авах бодлоготой хэвлэлийн ажлыг тэнд гүйцэтгэхээр тогтсон” /айлын талтай ярьж тохиролцсон/ хэмээн бас тодотгожээ.

–Гэвч Эрхүү “хотод монгол бичиг мэдэх хүнгүй” байна гэж учирлаад

–“Энэхүү намын хэвлэлийн ажилд монгол бичиг сайн мэдэх хүн чухал хэрэглэгдэх тул эндээс явуулан /Монголоос Т.Б./ эл ажилд туслалцан гүйцэтгэж байхаар тогтоод та нарын хойноос яаравчлан ирэв” гэж С.Данзан хэлж байна.

Үүнээс илүү тодорхойгоор, илүү ойлгомжтойгоор яаж хэлэх болж байна. “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн

гаргана” гэсний уг утга санааг ОК/б/Н ба Коминтерний нөхөд ч гүйцэд зөв ойлгож “ухуулга-хэвлэлийн” гэж орос хэлнээ орчуулсан аж. Монгол Ардын Намын төлөөлөгчид, Монголын

«

“Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана” гэсний уг утга санааг ОК/б/Н ба Коминтерний нөхөд ч гүйцэд зөв ойлгож “ухуулга-хэвлэлийн” гэж орос хэлнээ орчуулсан аж. Монгол Ардын Намын төлөөлөгчид, Монголын хувьсгалчид ингэж ойлгож байж. Намын хэвлэлийн ажил гэж утга агуулгыг тодотгосон байгаа юм. Тэр ажилд нь монгол хэл бичиг сайн мэдэх бичгийн хүн хэрэгтэй болжээ. Тийм хүнийг Монголоос явуулья гэж Эрхүүгийн нөхөдтэй ярьж тохиролцсон аж. Тэр нь сүүлд С.Буяннэмэх болсон байна. “Монголын үнэн” хэмээх Монгол Ардын Намын сониныг гардаж гаргалцахаар Монголоос очсон МАН-ын албан ёсны төлөөний хүн нь С.Буяннэмэх мөн гэдэг нь эндээс бүр ч тодорхой ойлгогдож байгаа юм

»

хувьсгалчид ингэж ойлгож байж. Намын хэвлэлийн ажил гэж утга агуулгыг тодотгосон байгаа юм. Тэр ажилд нь монгол хэл бичиг сайн мэдэх бичгийн хүн хэрэгтэй болжээ. Тийм хүнийг Монголоос явуулья гэж Эрхүүгийн нөхөдтэй ярьж тохиролцсон аж. Тэр нь сүүлд С.Буяннэмэх болсон байна. “Монголын үнэн” хэмээх Монгол Ардын Намын сониныг гардаж гаргалцахаар Монголоос очсон МАН-ын албан ёсны төлөөний хүн нь С.Буяннэмэх мөн гэдэг нь эндээс бүр ч тодорхой ойлгогдож байгаа юм. Өөр ч хэд хэдэн баримтаар давхар нотлогддог.

Доктор Г.Дэлэг, Л.Норовсүрэн нар С.Буяннэмэхийг Эрхүүд найман сар ажиллаж “Монголын үнэн” сонины 1920-1921 оны 6 дугаарыг бүгдийг бэлтгэж гаргалцсан гэж бичсэн. Харин доктор Б.Галаарид тэр худлаа, С.Буяннэмэх 1921 оны хавар Эрхүүд очсон нь судлаач Д.Дашийн тодорхойлсноор батлагдаж байгаа. “Монголын үнэн” сонины сүүлчийн ганц дугаарыг гаргахад л оролцсон байх магадлалтай гэж үзсэн. Эцэслэгдээгүй үргэлжилж буй нэг маргаан бол энэ юм. Гэхдээ Сономбалжирын Буяннэмэхэд “Өчүүхэн тэмдэглэл” нэртэй үнэт нийтлэл бий.

С.Буяннэмэхийн Эрхүү явсан цаг хугацааны талаарх баримжаалал авах баримт “Өчүүхэн тэмдэглэл” дотор байгаа юм. Тэр бол “Энэ лав нилээд их хүмүүс буй заа гэж би санаж байв. Гэнэт сонсвол тэр өндөр хүн нь “Энэ ямар хүн хэн бэ” гэж намайг асууж байна /Д.Сүхбаатарыг хэлж байна. Т.Б/. Түүний хамт орж ирсэн нөгөө нөхөр нь инээмсэглээд энэ чинь мөнөөх шүлгийг бичсэн хүн

шүү дээ гэж харин намайг таньж байна /Тэр нь Х.Чойбалсан. Т.Б/”. Тэр хүн түүнийг сонсоод даруй инээмсэглэх царайгаар намайг нилээд ажиглав. Урьд хэдэн өдрийн өмнө “Таван мөнгө хүрэхгүйгээр түмэн ардаа худалдсан халхын ноёд” гэх шүлэг бичээд Дамбадоржид өгсөн бөлгөө. Түүнээс өөр шүлгийг урьд хожид ер бичээгүй явсан тул лав түүнийг эдгээр нөхөд үзээд тийнхүү ярилцаж байгаа буй заа гэж дотроо тааварлаж байв” (Т.Баасансүрэн, 2022). Ингэж С.Буяннэмэх бичжээ. Энэ үнэн бол /зохиогч өөрөө юу гэж худал хэлэх билээ дээ/ уг үйл явдал, өрнөж буй цаг хугацаа 1920 оных болж таарах ёстой.

Яагаад гэвэл С.Буяннэмэх анхныхаа “Таван мөнгө хүрэхгүйгээр түмэн ардаа худалдсан халхын ноёд” шүлгийг 1920 онд бичсэн гэдэг нь доктор Лодонгийн Түдэв, Дожоогийн Цэдэв нарын судалгаагаар нэгэнт тогтоогджээ. “Урьд нь хэдэн өдрийн өмнө “Таван мөнгө хүрэхгүйгээр түмэн ардаа худалдсан халхын ноёд” гэх шүлэг бичээд Дамбадоржид өгсөн бөлгөө. Түүнээс өөр шүлгийг урьд хожид ер бичээгүй явсан тул лав түүнийг эдгээр нөхөд үзээд тийнхүү ярилцаж байгаа буй заа гэж дотроо таамаглав” хэмээн С.Буяннэмэх өөрөө бидэнд бичиж үлдээжээ. Өөр хүн биш зохиогч нь өөрөө ингэж хэлээд байгаа юм! Ийм баримтад итгэхгүй юм бол өөр юунд итгэх болж байна. Тэгэхлээр Сономбалжирын Буяннэмэх яах ч аргагүй 1920 оны сүүлчээр Хиагтад ирсэн болж таараад байгаа юм.

“Хэдэн өдөр өнгөрсний хойно Бодоо гаднаас орж ирээд надад хэлрүүн: За хүүе чамайг төв хорооны хурлаар хэлэлцэж Эрхүү хотод суух төлөөлөгчөөр томилсон тул одоо даруйхан явах хэрэгтэй. Замын зардал хэрэгслийг чинь сангийн хэлтэстэй ярилцсан тул тэндээс очиж авсугай гэв. Тэр Эрхүү хот бол Байгаль далайн хойно байдаг бөгөөд тэрхүү хотод Алс Дорнод зүгийн Коминтерний салбар болох газар байна. Тэнд манай итгэмжитэй нөхөр Ринченов гэгч бий бөгөөд тэндээс уламжилж манай монголд туслах цэрэг зэвсгүүд ирнэ. Бас тэндээс манай сонин ба хэвлэлүүдийг хэвлэж гаргана. Чиний бие очмогц чамд тэрхүү нөхөр Ринченов цөмийг зааж хэлж өгнө гэж ер учир нь олдохгүй янз бүрийн орос монгол үг хольж хутгаж нэлээд хэлж өгөв. Нарийн учрыг сайн ч мэдсэнгүй юу ч атугай явах л хэрэгтэй болов” (Т.Баасансүрэн, 2022) гэж С.Буяннэмэх “Өчүүхэн тэмдэглэл”-ээ цааш үргэлжлүүлжээ.

С.Буяннэмэхийг Эрхүү хотноо илгээх Ардын Намын төв хорооны шийдвэр гарчээ. Монгол Ардын Намын төлөөний хүнээр томилогдож байна. Бодоогийн хэлснээр бол Эрхүү хотод Алс Дорнод зүгийн Коминтерний салбар болох газар буй бөгөөд тэнд манай итгэмжит нөхөр Ринчинов гэгч бий. Тэндээс манай Монголд туслах цэрэг зэвсгүүд ирнэ. Бас тэндээс манай сонин ба хэвлэлүүдийг хэвлэж гаргана гэж тов тодорхой хэлсэн байна.

Доктор Б.Галаарид болохоор “Манай сонин ба хэвлэлүүдийг хэвлэж гаргана” гэснийг монгол судлаачид одоо цаг дээр биш ирээдүй цаг

дээр ойлгосноос эндүүрэл үүссэн гэж тайлбарласан. “Хэвлэж гаргана” гэдэг чинь өөрөө ирээдүй цаг дээр байгаа юм биш үү. Мөн доктор Б.Галаарид Эрхүүгээс С.Данзанг Монголд Сүхбаатар нарын араас яаравчлан буцаж ирэхэд “Монголын үнэн” сонины хоёр ч дугаар гарчихсан байсан гэж сануулсан байгаа. Гэтэл С.Буяннэмэхийн “Өчүүхэн тэмдэглэл”-д тэр тухай юу ч дурдсангүй. Гагцхүү “Бас тэндээс манай сонин ба хэвлэлүүдийг хэвлэж гаргана” гэж хэлснийг л онцолжээ. Хэрэв “Монголын үнэн” сонины анхны дугаарууд хэвлэгдчихсэн, тэр нь хилээр ороод Монголд ирчихсэн байсан бол хамгийн түрүүнд С.Буяннэмэх түүнийг олж үзэх байсан /Ардын хувьсгалын түүх судлаачид “Монголын үнэн” сонины анхны уншигчид нь 1921 оны ардын хувьсгалыг мандуулагч партизан цэргүүд, хойт хилийн харуулууд байсан гэж бичсэнийг уншсанаа санаж байна/, би ийм сонины ажилд оролцох үүрэг даалгавар авч байгаа юм байна гэдгээ ойлгож мэдрэх ёстой бус уу. Тийм юм “Өчүүхэн тэмдэглэл”-д алга. Харин “Нарийн учрыг ч сайн мэдсэнгүй юу ч атугай явах л хэрэгтэй болов” гэж бичиж үлдээжээ. Тэгэхээр С.Буяннэмэхийг Эрхүү явах хүртэлх хугацаанд “Монголын үнэн” сонин хэвлэгдээгүй байжээ гэж үзэж болох юм бишүү? Хэвлэгдсэн байлаа гэхэд хил давж орж ирээгүй байсан байна. Бодоогийн ярианаас Монголд туслах Оросын цэрэг зэвсгүүд, тэндээс хэвлэж гаргах манай сонин хэвлэлүүдийн аль аль нь Монголд орж ирээгүй байжээ. Тэр ажлыг газар дээр нь гардан гүйцэтгүүлэхээр

С.Буяннэмэхийг явуулж байгаа, чамд бүх зүйлийг Ринчинов хэлж өгнө л гэсэн аж.

“Элдэв зүйлийн бодлогот бичиг” гэсэн нэр томъёотой холбогдуулж эдгээр үгсийг Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д хэрхэн яаж тайлбарласныг сөхөж үзлээ. 2021 онд Улаанбаатар хотноо хэвлүүлсэн эл толь бичиг нь нэмж дэлгэрүүлсэн дөрөв дэх хэвлэл аж. Зохиогчийн төрсөн хүү, хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Ц.Шагдарсүрэн үг, утга, жишээ, тайлбар, хавсралт тэргүүтнийг хянаж нягталсан байна.

Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д: **Бичиг-авиа** буюу дүрсийг тэмдэглэж бичих үгсийн тогтолцоо /толийн 114 дэх тал/, **Бодлоготой-** иш үндэстэй, буурь суурьтай,

болгоомж сайтай /толийн 118 дахь тал/, **Бодлогогүй-** санаа бодолгүй, болгоомжгүй, иш үндэсгүй, суурьгүй; чи яасан бодлогогүй хүн бэ? Бодлогогүй бол боол болно /толийн 118 дахь тал/, **Элдэв-** зүйл зүйлийн, янз янзын, төрөл бүрийн. Элдэв зүйл /олон зүйл/ /толийн 1267 дахь тал/ (Я.Цэвэл, 2021) гэж тус тус утгыг тайлж тайлбарлажээ.

Ингэхлээр бичиг гэдэг нь авиа буюу дүрсийг тэмдэглэж бичих үг-

сийн тогтолцоо юм байна. Үгсийн тогтолцооноос яах ч аргагүй утгын тогтолцоо үүсэж бүрддэг. Бодлоготой гэдэг нь иш үндэстэй, буурь суурьтай, болгоомж сайтай гэсэн санаа аж. Өөрөөр хэлбэл урьдаас иш үндэстэй, ул суурьтай бодож боловсруулсан бичлэгийг бодлогот бичиг гэж ойлгох ёстой болж байна. Бодлогогүй гэхээрээ өөдтэй, ул үндэстэй санаа бодолгүй, болгоомжгүй, иш

үндэсгүй, буурь суурьгүй зүйл болж хувирах нь. Бодлогогүй бол боол болно гэж утгачлан тайлбарлаж жишээлсэн байна. Элдэв гэдэг үг нь зүйл зүйлийн, янз янзын, төрөл бүрийн, элдэв зүйлийн утга санааг илэрхийлнэ гэж тов тодорхой тайлбарлажээ.

Тэгэхлээр “Элдэв зүйлийн бодлогот бичиг” гэдэг нь зүйл зүйлийн, олон янзын утга санааг бодлоготойгоор, өөрөөр

хэлбэл иш үндэстэй, буурь суурьтай, болгоомж сайтайгаар бодож боловсруулсан үгсийн тогтолцоо буюу түүний утгын тогтолцоо болж таарч байгаа юм. 1921 оны ардын хувьсгалыг үүсгэн ялалтад хүргэхийг хүсэмжлэгч Ардын намын анхдагчид чухам энэ утгаар “Элдэв зүйлийн бодлогот бичиг” гаргахыг зорьж байжээ. Өөрөөр хэлбэл зүйл зүйлийн, олон янзын санааг бодлоготойгоор, иш үндэстэй, буурь суурьтай, бол-

«

“Элдэв зүйлийн бодлогот бичиг” гэдэг нь зүйл зүйлийн, олон янзын утга санааг бодлоготойгоор, өөрөөр хэлбэл иш үндэстэй, буурь суурьтай, болгоомж сайтайгаар бодож боловсруулсан үгсийн тогтолцоо буюу түүний утгын тогтолцоо болж таарч байгаа юм. 1921 оны ардын хувьсгалыг үүсгэн ялалтад хүргэхийг хүсэмжлэгч Ардын намын анхдагчид чухам энэ утгаар “Элдэв зүйлийн бодлогот бичиг” гаргахыг зорьж байжээ

»

гоомж сайтайгаар бодож боловсруулж урьдчилан бэлтгэсэн үгсийн тогтолцоо буюу утгын тогтолцоо бүхий бичиг гаргахыг эрмэлзэж байжээ. Энд “Олны сэтгэл хөдөлгөсөн” хэмээх өгүүлбэрийн толгойн эхлэл хэсгийг тайлбарлах ямар ч шаардлагагүй буй заа. Яагаад гэвэл бүгдэд маш ойлгомжтой үг хэллэгээр малгайлжээ. Олон түмний сэтгэлийг хөдөлгөх, тэдний сэтгэлийг татах гэж гол зорилгоо тодорхойлжээ. Олон түмний анхаарлыг татах, тэдний сэтгэлийг хөдөлгөх зорилгоор “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг”-ийг хэвлэж гаргана гэж хэлсэн байна.

Ингэхлээр энэ утга нь ухуулах хуудас, уриалга гэхээсээ илүүтэйгээр сонин сэтгүүлд, бүр тодруулбал “Монголын үнэн” сонинд хамаарагдах ёстой юм биш үү гэсэн сэтгэгдлийг өөрийн эрхгүй төрүүлж байгаа болно. 1919 оноос эхлэн нууц ухуулах хуудас гаргаж энд тэндгүй наалдуулан тарааж эхэлсэн Д.Сүхбаатар нарын ардын намын гэшүүд хувьсгалчид зөвхөн үүндээ сэтгэл ханана гэж яавч үгүй. Тэмцлээ улам гүнзгийрүүлж ухуулах хуудас, уриалгаа улам боловсронгуй болгохыг зорьж байсан нь, өөрөөр хэлбэл “Элдэв зүйлийн бодлогот бичиг” буюу “Монголын үнэн” сониныг үүсгэн гаргахад хүргэсэн нь дамжиггүй бизээ.

Тусламж гуйхаар Орост очсон Монголын хувьсгалчдын хүсэл эрмэлзэл, тусламж үзүүлэх замаар нөлөөний бүсээ өргөжүүлэх, Монголд өөрийн үзэл номлолыг дагасан хувьсгалт засаглалыг тогтоох ОК/б/Н ба Коминтерний зорилго зорилт хоёр нэг цэг дээр нийлж

нэгджээ. Энэ нь айлын талд албан ёсоор гардуулсан “Намын ойрын зорилтын талаарх санал”-аас нь ч мэдрэгдэж байна. Нэгдүгээрт гэж эрэмбэлж байгаад **олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг** хэвлэн гаргана гээд улмаар бичиг цэргийн оньсон арга сургах сургуулийн хүн нарыг Эрхүү хотын газар илгээх ба олон газрын Ардын нам лугаа нэвтрэлцэх хэргийг эрхэлнэ хэмээжээ. Харилцаа холбоо, хамтын ажиллагаагаа хүсэл эрмэлзэл нэгтэй олон намтай өргөжүүлнэ гэдгээ ил тодоор ойлгуулсан байна. Энэ бол Монгол Ардын Нам Коминтерний гэшүүн нам, түүний нэг мөчир салаа нь болсны илэрхийлэл юм. Өөрийн гэшүүн намдаа зүйл бүрийн, түүний дотор санхүү, эдийн засгийн тусламж үзүүлэх нь Коминтерний үүрэг, зорилттой таарч байгаа юм. ОК/б/Н-ын бодлого ч ийм байжээ.

Зөвлөлт Орост тусламж эрж очсон МАН-ын төлөөлөгчдийн хувьд чулуун барын хэвлэх үйлдвэртэй болж түүгээрээ ухуулах хуудас зэргийг хэвлэх ажлыг Монголдоо хийх хүсэлтэй байсан нь “Дараа нь эндээ, Эрхүүд монгол хэл дээр зохиол хэвлэх ажлыг зохион байгуулах” (Б.Галаарид, 2021) гэж ялгаж салгаж хэлснээс тодорхой байна гэж доктор Б.Галаарид “Монголын үнэн” сонины бодит түүх” /УБ.2021/ номондоо бичжээ. Надад бол орос эх дээрх “Организовать издание литературы на монгольском языке” гэж байгаа нь ганц уран зохиол гэсэн ойлголт хараахан биш, улс төрийн зохиол бүтээлүүд гэсэн ерөнхий, өргөн утга санааг илэрхийлжээ гэж ойлгогдож байгаа юм. Харин Б.Галаарид орос эхэд “литература” гэж байгаа нь

гараар бичсэн, хэвлэсэн дурын бичвэрийг илэрхийлсэн гэж үзлээ гэсэн байна.

Орос хэлэнд “литература” гэдэг үгийг маш өргөн утгаар хэрэглэдэг бөгөөд үүнд бүх төрлийн хэвлэмэл бүтээлийг багтаадаг. Тухайлбал, судалгааны бүтээлд ашигласан сонин, сэтгүүлээс эхлээд нэг сэдэвт бүтээлийн жагсаалтыг хүртэл бүхэлд нь “литература” гэж нэрлэдэг нь үүний нэг баталгаа мөн.

Эрхүүд монгол хэл дээр улс төрийн зохиол бүтээл хэвлэх тухай ярьж байна гэж ойлгох юм бол түүнийг зөвхөн зохиол гэж явцуурахгүйгээр илүүтэй түгээмэл өргөн утгаар ойлгох нь зүйтэй юм. Улс төрийн зохиол дотор чинь сэтгүүл ч, сонин ч бас орно шүү дээ. “Монголын үнэн” сониныг “Эрхүү хотноо Дорнын ард түмнүүдийн секцийн дэргэд хоёр долоо хоног тутмын Монголун үнэн утгайн сэткул “Монгольская правда” ухуулгын сонин хэвлэгдэж байна (Б.Галаарид, 2021) гэж ОК/б/Н-ын Сибирийн товчооны дорнын ард түмнүүдийн Секцийн Монгол-Түвдийн хэлтсийн лавлагаа хэмээх гарчиг бүхий баримтад бичээстэй буйг судлаач өөрөө эш татжээ. Үнэхээр “Монголын үнэн” сонины 6 дугаар бүрийн толгойн дор сэтгүүл гэж тодотгож нэрлэсэн байгаа. “Энэхүү Монголын үнэн хэмээх сэтгүүлийг Дорно зүгийн олон улсын хорооны Монгол Төвөдийн хэлтсээс тархаамой” гэж буй.

Мөн түүнчлэн Оросод очсон МАН-ын төлөөлөгчид хэмжээ багатай ухуулах хуудас, уриалга зэргийг хэвлэж болох чулуун барын хэвлэх үйлдвэр хүссэнийг зөвхөн ухуулга

хуудас, уриалга төдийхөн хэвлэхээр гэж махчилж ойлгох нь зөв үү?

Ухуулах хуудас, уриалгын дайны хэмжээтэй одой сонинг хэвлэн гаргаж байсан баримт өнгөрсөн түүхэнд нэг биш. Цаг хугацаатай уралдсан, явдал чирэгдэл багатай авсаархан одой хэвлэл ялангуяа хувьсгалт тэмцлийн он жилүүдийн нүүдэл, суудал ихтэй яаруу сандруу цаг үед илүү тохиромжтой байсан ч байж болох юм. Шуурхай мэдээ зангийг сударлаж барлаад тараадаг уламжлал дорно дахины улс орнуудад түгээмэл, Монголд ч бас байсан. Их Монгол Улсын түүх судлаач доктор, профессор Ойдовын Нямдаваагийн туурвисан “Цагаадай улсын өв соёл” /2022/ номд “Цагаадай хааны төв Азид хийсэн 4 гол зүйлийн нэг нь тэднийг нэгэн хэлээр хоорондоо ойлголцдог, бас ярьдаг, улмаар бичдэг болгосон явдал байсан. Цагаадай хэлний тулгуур нь узбек, киргиз, уйгар, түрэг, казах, монгол хэл байсан бололтой. Хожим нь ислам шашнаар дамжин перс, араб хэлний нөлөө их орсон. Мэдээж тухайн үед шинэ хэлийг ямар хэл гэж нэрлэх асуудал гарсан нь ойлгомжтой. Түүнийг нь зохицуулах гол гарц нь цагаадай хэл гэж нэрлэхэд хэн ч эсэргүүцэж чадахгүй байсан бололтой. Ингэж цагаадай хэлний түүх тавигдаж, тухайн үеийн утга зохиол, улс төрийн хэл болон цэцэглэн хөгжиж улмаар 700-800 гаруй жилийн түүхтэй болжээ. Өөрөөр хэлбэл Цагаадайн улсын /Төв Азийн орнуудын/ болон Монголын эзэнт улсын зарим түүх энэ хэлээр бичигдэж үлджээ” (О.Нямдаваа, 2022) гээд цагаадай хэлээр 7 хоног тутам гаргаж байсан

сэтгүүлийн нүүр хуудсыг өөрийн номдоо оруулжээ. 1883 онд 7 хоног тутмын ийм сэтгүүл гаргаж байжээ. Бүр ойрхоны жэшээнээс эш татах юм бол 1921 оны Ардын хувьсгалын дараагаар /1922-1923 онд/ “Уриа” сонин, МОНТА агентлагаас хамтран монгол, орос хэл дээр долоо хоногт 2-3 удаа гаргаж байсан “Хураангуй сэтгүүл” /Бюллетень МОНТА/ гэхэд л томоохон ухуулах хуудсын дайтай л хэвлэгдэж байсан бэлээхэн жэшиг ч байна.

Доктор Б.Галаарид “Хүрээний газар ардын намын гол хороог байгуулж хэргийг хөтлөх хүмүүсийг сонгоод “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана” гэжээ. Эндээс олон түмний санаа сэтгэлд нөлөөлөх бичгийг бодлогоор бэлтгэн хэвлэнэ гэсэн утга уншигдаж байгаа ч тэр нь ухуулах хуудас, уриалга уу, эсвэл сонин сэтгүүл үү гэдэг хэлбэрийг тодорхойлоход хэцүү байна” (Б.Галаарид, 2021) гэжээ.

Харин ч хэцүү биш санагдана. Уншигч олон түмний санаа сэтгэлийг хөдөлгөх төрөл бүрийн сэдэвтэй, тодорхой бодлогоор бэлтгэгдсэн бичмэл хэвлэлийн бүтээгдэхүүнийг хэвлэн гаргана гэж маш тодорхой хэлжээ. Чухамхүү сонин, сэтгүүлийг л хэлж буй юм биш үү. 1921 оны хувьсгалчид сонин, сэтгүүлийг “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг” хэмээн ойлгож байжээ. Энэ нь надад тогтмол хэвлэлийг сонин, сэтгүүл гэж ялгаснаас ердутах юмгүй, харин ч илүү тод оносон тодорхойлолтот хэллэг мэт тун аятайхан санагдаж байна. Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг гэж үндэсний аялгуу

сайхан монгол хэл бичгээрээ урамтай тод томруун, туйлын ойлгомжтойгоор утга агуулгыг тодорхойлсон байгаа юм.

Судлаач Б.Галаарид Монголын хувьсгалчдад орчуулга хийж байсан Элбэгдорж Ринчиногийн орос, монгол хэлний төгс мэдлэгт эргэлзэх хэрэггүй (Б.Галаарид, 2021) гэж номондоо тэмдэглэсэн байсан, нээрээ ч тэр үнэн байх. Монгол хэлнээс орос руу түүний орчуулсан байж болох өндөр магадлалтай орос эх дээр “Элдэв зүйлийн бодлогот бичиг” гэснийг “Ухуулга-хэвлэлийн” гэж товчоор утгачилж буулгасан байдаг. Уг үгийг хэрхэн яаж орос руу орчуулж үндсэн санааг ойлгогдхоор тод томруун буулгах вэ гэдгийг тэрбээр эрхбиш Монголын хувьсгалчидтай зөвлөлдөж утга агуулгыг тодруулсан байж таарна. Дур мэдэж өөрөө өөрчлөөгүй байлгүй. “Ухуулга-хэвлэлийн” гэж байгаа нь ухуулах хуудас, уриалга хийгээд сонин сэтгүүлийг нийтэд нь хамаатуулан ойлгож буйг тодорхой зааж буй хэрэг юм.

Гэтэл Б.Галаарид “Энэ үед монголчуудын хувьд сонин, сэтгүүл гэдэг нэршил, ойлголт аль хэдийн танил болсон байсан гэдгийг харгалзан үзвэл “Элдэв зүйлийн бодлогот бичиг” гэдэг нь ухуулга, сурталчилгаа, уриалга зэргийг хэлсэн байх магадлал өндөр байна. Түүнээс биш сонин сэтгүүл эрхлэн гаргах хүсэлтэй байсан бол шууд л сонин, эсвэл сэтгүүл хэмээн тодорхой зааж өгүүлэх ёстой” (Б.Галаарид, 2021) гэж өөрийнхөөрөө тайлбарлажээ. Монгол хэл бичиг, түүний үгсийн сангийн өв их соёл, утга агуулгыг илэрхийлэх баялаг олон янз хэлбэр, солонгорсон

өнгө хувилбар бүхий үнэт өв уламжлалд өнөөгийн байр сууринаас эдүгээчилж байгаад харьцангуй захиргаадаж тулган хүлээлгэх гэж оролдох нь тун тусгүй гэж би бодож байна. Тэгж яривал “Монголын үнэн” сонины 1920-1921 оны бүх зургаан дугаарыг эрхлэн гаргагчид нь өөрсдөө сэтгүүл гэж тодотгон нэрлэсэн байгаа шүү дээ.

Одоогоор 1919-1921 оны хооронд гаргаж Хүрээний энд тэнд нууцаар наалдуулж байсан ухуулгын хуудсуудыг санаачлан зохиогчдын нэг нь Дамдины Сүхбаатар гэдэг нь тодорхой байгаа. Мэдэгдэж буй нөгөө нэг зохиогч нь Сономбалжирын Буяннэмэх 1921 оны VII сарын 1-нд “МАН-ын Эрхүү хотноо суугаа төлөөний хүн Буянхүү /Буяннэмэх/ нарын бичиг” нэртэй ухуулах хуудас гарч байсан нь одоо манай улсын архивын сан хөмрөгт хадгалагдаж байдаг билээ” (Г.Дүйнхэржав, 1997) гэж судлаач Г.Дүйнхэржав өөрийн бичсэн “Сономбалжирын Буяннэмэхийн улс төрийн намтар” номондоо тэмдэглэсэн байдаг. Оросын хувьсгалч Б.Шумяцкий “Монголын октябрийн 10 жилийн ой” хэмээх дурсамждаа С.Буяннэмэхийг тухайн “цаг үеэ ухамсарлаж, амьдралын зорилгоо таньж 1920 оны 4 дүгээр сард... Сүхбаатарын байгуулсан хувьсгалт бүлгэмд элссэн” (Б.Шумяцкий, 1966) гэжээ. Хувьсгалчдын ухуулах хуудсыг бичиж зохиох, энд тэнд нууцаар наалдуулж тараах ажилд 1921 оны ардын хувьсгалчдаас цөөнгүй нь оролцсон байх магадлалтай нь ойлгомжтой. Тэднээс баримт нотолгоотой, баталгаатай мэдэгдэж буй зохиогчид нь харин Д.Сүхбаатар, С.Буяннэмэх нар байгаа юм.

Ер нь аливаа хувьсгалт тэмцэлд оролцогсод үйл ажиллагаагаа нууц ухуулах хуудас бичиж нууцаар энд тэнд наалдуулж тараахаас эхлээд улмаар түүнийгээ өргөжүүлэн гүнзгийрүүлж бичмэл сонин, сэтгүүл болгож өргөжүүлдэг нь бүх улс оронд түгээмэл, түүний дотор Монгол Улсад өрнөсөн 1921 оны ардын хувьсгал, 1990 оны ардчилсан хувьсгалын практикаас ч их тод харагддаг. Энэ нь хувьсгалт тэмцлийн өрнөлийн бараг нэгэн зүй тогтол ч байж мэдэх юм.

Эдгээр баримт сэлт нь 1920 оны 8 дугаар сард Орос улсад тусламж гуйж очсон манай хувьсгалчдын “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг” хэвлэн гаргахад минь тусламж үзүүлнэ үү гэсэн хүсэлт айлын талын дэмжлэг авч тун удалгүй биеллээ олоод “Монголын үнэн” сэтгүүл гэдэг нэрээр мэндэлжээ гэж үзэх боломжийг бидэнд олгож байгаа юм. Ингэж ганц би үзэж буй юм бишээ, доктор Г.Дэлэгээс эхлээд Монголын сэтгүүл зүйн үе үеийн судлаачид ийнхүү нотолж бичиж тэмдэглэж ирсэн байдаг билээ.

Дүгнэлт. Нэгдүгээрт, Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана хэмээсэн Монгол Ардын Намыг төлөөлөгч ардын хувьсгалчдын энэхүү нэр томъёог тайлж унших, утга агуулгыг тодотгох түүхэн ач холбогдол бүхий дор дурдсан бодит баримтууд байна. Үүнд:

1.Тусламж гуйхаар Орос улсад очсон Монгол Ардын Намын төлөөлөгчид хувьсгалыг мандуулж өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд ухуулга сурталчилгаа хэвлэл мэдээллийн үйл

ажиллагаа нэн чухал болохыг сайтар мэдэж мэдэрч байсан тул 1920 оны 8 дугаар сарын 18-20-нд Эрхүү хотноо болсон хоёр талын уулзалт дээр авсаархан хэвлэх үйлдвэртэй болохыг хүсэж хэвлэлийн асуудлыг анх Монголын талаас хөндөж тавьсан байна.

2. Эдгээр ажлыг удирдан зохион байгуулж практик ажил хэрэг болгох үндсэн үүрэгтэй ОК/б/Н-ын Сибирийн товчооны Монгол-Түвдийн хэлтсийг /Коминтернтэй хамтарч/ зохион байгуулах хуралд Д.Бодоо, Х.Чойбалсан нар биечлэн оролцож уг нэгжийг байгуулалцсан ба Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарыг тус хэлтсийн үйл ажиллагаанд татан оролцуулахаар шийдвэрлэжээ. Уг хэлтэс дотор Ухуулга сурталчилгаа, хэвлэлийн дэд хэлтсийг мөн байгуулж Х.Чойбалсанг редакцын зөвлөлийн гэшүүний эрхтэйгээр үйл ажиллагаанд нь оролцуулахаар тохиролцсон байна.

3. Эл түүхэн үйл явдлыг Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нар өөрсдийн туурвисан “Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэн байгуулагдсан товч түүх” /УБ. 1934/ номонд бичиж үлдээсэн, түүнийг нь доктор Г.Дэлэг “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” /УБ. 1965/ номондоо баримт болгон авч ашигласан байна.

4. 1920 онд Эрхүүд очсон Ардын Намын төлөөлөгчдөөс түр хугацаагаар тэндээ үлдсэн С.Данзан намын хэрэг ажлыг олон түмэнд зарлах элдэв бичиг зарлал буюу харгис гэмин, зандалчин цагааныг муушаан шүүмжилж элэглэн дуурайлгасан зурагтай ухуулга сэтгүүлийг яаралтай гаргаж олны сэтгэлийг татан харгис зандалчингаас жигшүүлэн салгаж авах

хэвлэлийн ажлыг тэнд гүйцэтгүүлэхээр тогтсон. Гэвч Эрхүү хотноо монгол бичиг мэдэх хүнгүй, тийм хүнийг монголоос очуулахаар Эрхүүгийн эрх баригчидтай ярилцаж тохиролцсон тул яаравчлан та нарын араас хүрч ирлээ гэж намын нөхөддөө учирлажээ.

5. Энэ дагуу С.Буяннэмэхийг МАН-ын төлөөний түшмэлээр томилон Эрхүүд очуулж “Монголын үнэн” сонины ажилд оролцуулж байгаа, тэрчлэн Д.Сүхбаатарын хүсэлтээр сүүлд 1921 оны Ардын хувьсгалын ялалтын дараагаар Судар бичгийн хүрээлэнгийн даргаар томилогдсон Онход Жамьян монгол бичиг үсгийн чадвартай Ч.Пүрэвийг мөн уг ажилд дайчлан хүчин туслалцуулсан зэрэг баримт түүхэнд тэмдэглэгдэж үлдсэн байна. С.Буяннэмэх өөрийн бичсэн “Өчүүхэн тэмдэглэл” нийтлэлдээ Д.Бодоо надад “тэндээс манай сонин хэвлэлүүдийг хэвлэж гаргана” гэж хэлсэн хэмээжээ. Өөрөөр хэлбэл С.Буяннэмэхийг Эрхүү рүү явахаас өмнө “Монголын үнэн” сонины дугаарыг 1921 оны ардын хувьсгалчид хүлээж авч үзэж танилцаагүй байсан нь эндээс мэдрэгдэж байгаа юм.

6. Монгол Ардын Нам, Монголын хувьсгалчдаас “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана” гэсэн саналыг айлын тал монголоос орос руу хөрвүүлэхдээ “ухуулга-хэвлэлийн” гэж утгыг тодотгожээ. Энэ нь ганц ухуулга хуудас уриалгаар хязгаарлагдаагүй, хувьсгалт хэвлэлийн үйл ажиллагаа гэсэн өргөн утга агуулгыг илтгэн илэрхийлж байна.

7. Монгол хэл бичиг шинжлэлийн үүднээс, тухайлбал Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д

“Элдэв зүйлийн бодлогот бичиг” гэсэн ухагдахууныг тайлж тайлбарласныг авч үзвэл олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг гэдэг нь ухуулга уриалгаас илүү гүн гүнзгий утгыг, өөрөөр хэлбэл сонин сэтгүүлийн нийтлэлийн агуулгыг илүүтэй илэрхийлж байгааг ойлгож мэдэж болохоор байна.

8. Эдүгээгээс зуу гаруй жилийн тэртээд буюу өнгөрсөн зууны эхээр хувьсгалт тэмцэл хөдөлгөөн өрнөсөн дэлхийн бусад улс орнууд, түүний дотор Монголд ч ялгаагүй авсаархан хэмжээний одой хэвлэлийг түгээмэл ашиглаж байсан нь хувьсгалт тэмцлийн он жилүүдийн нүүдэл, суудал ихтэй яаруу сандруу цаг үед илүү тохиромжтой байсан байна. Хэмжээ багатай ухуулга хуудас, уриалга зэргийг хэвлэж болох жижигхэн чулуун барын хэвлэх үйлдвэр зайлшгүй хэрэгтэй байна. Монгол хэл дээр зохиол хэвлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай гэж манай хувьсгалчид учирлаж байсан нь ухуулга сурталчилгааг ихэд чухалчилж сонин сэтгүүлийг хүсэмжилж байсныг илтгэнэ.

9. Дэлхий дахины улс орнууд, тэрчлэн Монголд өрнөсөн 1921 оны ардын хувьсгал, 1990 онд ялсан ардчилсан хувьсгалын өнгөрсөн практикаас харахад аливаа хувьсгалт үйл ажиллагаа, тэмцэл хөдөлгөөн нь ухуулах хуудас үйлдэж энд тэнд нууцаар тарааж наалдуулахаас эхлээд улмаар хэвлэмэл сонин, сэтгүүл болж өргөжин гүнзгийрдэг зүй тогтолтой байж болохыг харуулж байна.

Хоёрдугаарт, Эдгээр хөдөлшгүй баримтууд нь 1920 оны 8 дугаар сард Орос улсад тусламж гуйж очсон

Монгол Ардын Намыг төлөөлөгч хувьсгалчдаас айлын талд албан ёсоор бичгээр өргөн барьсан “Намын ойрын зорилтын талаарх санал”-ын 5-р зүйлд тодорхойлсон “Хүрээний газар ардын намын гол хороог байгуулж хэргийг хөтлөх хүмүүсийг сонгоод, нэгд, “Олны сэтгэл хөдөлгөсөн элдэв зүйлийн бодлогот бичиг хэвлэн гаргана” хэмээн томьёолсон нь *зөвхөн ухуулах хуудас, уриалга төдийхөн ойлголтгоор хязгаарлагдсангүй, хүн ардад хүрч нөлөөлөн олон түмний сэтгэлийг өөртөө татах сонин, сэтгүүл буюу өөрөөр хэлбэл МАН-ын мөрийн хөтөлбөр, бодлого зорилго, стратеги тактикийг тайлбарлан таниулж, ухамсарлуулан ойлгуулж ардын хувьсгалыг зэвсэгт тэмцлийн замаар ялалтад хүргэхэд эр эм, хар шар, эзэн зарц гэж ялгалгүйгээр Монголоо гэсэн хүн бүрийг нэгтгэж дайчлан зохион байгуулан хувьсгалыг үзэл суртлын талаас хангагч “Монголын үнэн” хэмээх хилийн чанад дахь дайчин хэвлэлийг буй болгож Монголд нууцаар оруулж ирэн тараах үндсэн гол зорилгыг агуулж байсан ажгуу* хэмээх гаргалгааг гаргах боломжийг бидэнд олгож байгаа болно.

Эшлэл

1. Сүхбаатар. Түүхийн баримтуудын цоморлиг. УБ. 1959. 65 дахь тал
2. Л.Норовсүрэн. Сэтгүүл зүй /21 боть зохиол. V боть/ УБ. 2019. 59 дэх тал
3. Урианхан Б.Галаарид. “Монголын үнэн” сонины бодит түүх. УБ. 2021. 38 дахь тал
4. Чойбалсан.Х, Лосол.Д, Дэмид.Г. УБ.2014. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх. 107 дахь тал

5. Урианхан Б.Галаарид. “Монголын үнэн” сонины бодит түүх. УБ. 2021. 61-62 дахь тал
 6. Протокол № 1 организационного заседания коллегии Монголо-Тибетского отдела секции восточных народов Сиббюро РКП /б/ 20 августа 1920 г- Монголия в документах Коминтерна /1919-1934/ в 2 ч3-ч1 /1919-1929/ Улан-үдэ, с 34
 7. Г.Дэлэг. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ. 1965. 226 дахь тал
 8. Урианхан Б.Галаарид. “Монголын үнэн” сонины бодит түүх. УБ. 2021. 125-126 дахь тал
 9. Лэгсрэн овогт Тугалхүүгийн Баасансүрэн. Нэгэн жарны сударласан сургамж. /Утга зохиол, сэтгүүл зүй, орчуулгын бүтээлийн шүүмж судлал/ “Өчүүхэн тэмдэглэл” дэх өчнөөн олон мэдээлэл, түүний түүхэн чухал ач холбогдол. УБ. 2022. 235 дахь тал
 10. Лэгсрэн овогт Тугалхүүгийн Баасансүрэн. Нэгэн жарны сударласан сургамж. /Утга зохиол, сэтгүүл зүй, орчуулгын бүтээлийн шүүмж судлал/ “Өчүүхэн тэмдэглэл” дэх өчнөөн олон мэдээлэл, түүний түүхэн чухал ач холбогдол. УБ. 2022. 235 дахь тал 237 дахь тал
 11. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь /нэмэн дэлгэрүүлсэн дөрөв дэх хэвлэл/. УБ. 2021. 114, 118 ба 126 дахь тал
 12. Урианхан Б.Галаарид. “Монголын үнэн” сонины бодит түүх. УБ. 2021. 38 дахь тал
 13. Урианхан Б.Галаарид. “Монголын үнэн” сонины бодит түүх. УБ. 2021. 48 дахь тал
 14. О.Нямдаваа. Цагаадайн улсын өв соёл. УБ.2022. 95 ба 97 дахь тал
 15. Урианхан Б.Галаарид. “Монголын үнэн” сонины бодит түүх. УБ. 2021. 39 дэх тал
 16. Мөн номын 44 дэх тал
 17. Мөн номын 39 дэх тал
 18. Г.Дүйнхэржав. Сономбалжирын Буяаннэмэхийн улс төрийн намтар УБ. 1997. 9-10 дахь тал
 19. Б.Шумяцкий. “Монголын октябрийн 10 жилийн ой” /1931/. Эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл. МАХН-ын түүхийн институт. УБ. 1966
- Ашигласан бүтээлийн жагсаалт**
1. Урианхан Галаарид.Б. “Монголын үнэн” сонины бодит түүх. УБ. 2021
 2. Дүйнхэржав.Г. Сономбалжирын Буяаннэмэхийн улс төрийн намтар. УБ. 1997
 3. Дэлэг.Г. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ. 1971
 4. Зөвлөлт анд нөхөд Сүхбаатарын тухай /Эмхэтгэсэн Д.Даш/ УБ. 1980
 5. Монголын үнэн /1920-1921 онд хэвлэгдсэн зургаан дугаарын эмхэтгэл/ УБ. 2023
 6. Сүхбаатар. Түүхийн баримтын цоморлигууд. УБ. 1959
 7. Цэвэл.Я Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 2021
 8. Чойбалсан.Х, Лосол.Д, Дэмид.Г. Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэн байгуулагдсан товч түүх. УБ. 2014
 9. Баасансүрэн.Т. Нэгэн жарны сударласан сургамж /”Өчүүхэн тэмдэглэл” дэх өчнөөн олон мэдээлэл, түүний түүхэн чухал ач холбогдол”/. УБ. 2022
 10. Баасансүрэн.Т. “Монголын үнэн” сонин монголчуудын оюун санааны үнэт өв, монгол үндэстний өмч мөн. УБ. 2024
- Keywords:** Niislel Khuree, secret revolutionary groups, Mongolian People's Party, secret revolutionary leaflets, "Mongoliin Unen" newspaper, Mongolia-Tibetan Department.